



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/103

Мөрөн

Орлого бүрдүүлэх, өр, авлагыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "е", 29.1.6 "л", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дахь хавсралтын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс оронд үүссэн эдийн засгийн хямрал, төсвийн хомсдолтой үед орлогын эх үүсвэрийн төлөвлөгөөг сард нь багтаан бүрдүүлж, хуваарилж, зарцуулах, өр, авлагыг барагдуулах зорилгоор нийт төсвийн байгууллагын төсөв захирагчид болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудад даалгах нь:

1.1. Цалин, хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, холбогдох татварын тооцоог сар бүрийн 20-ны дотор багтаан гүйцэтгэж дуусгаж хэвших.

1.2 2016 оны жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэл, татварын өглөгтэй гарсан байгууллагууд 2017 оны 1-р улиралд багтаан холбогдох татвар, шимтгэлийн тооцоог барагдуулж дуусган цаашид өглөг үүсгэхгүй ажиллах

1.3 Цалин, хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, холбогдох татварын тооцоог санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн дарааллыг баримтлан эхний ээлжинд тооцон шилжүүлэх.

2. Сумын татварын болон нийгмийн даатгалын байцаагч нарт татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог сард нь багтаан бүрдүүлж, хуваарилж, төвлөрүүлэх талаар холбогдох чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллахыг аймгийн Татварын хэлтсийн дарга /Ч.Хуншагай/, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга /Л.Юмжирдулам/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Төрийн сангийн төлбөр тооцоог дээр дурдсан дарааллын дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулан ажиллахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

c:\My Documents-A\103

13 0286